



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 31 өдөр

Дугаар A117

Улаанбаатар хот

“Автобустай аялал” зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалт, нийслэлийн Засаг даргын 2024 оны А/605 дугаар захирамж, нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар батлагдсан Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Олон Улсын “Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан “Автобустай аялал” арга хэмжээг зохион байгуулсугай.

2.Арга хэмжээнд шаардагдах зардал 1,075,000 (нэг сая далан таван мянга) төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч (Д.Уянга)-д зөвшөөрсүгэй.

3.Арга хэмжээг зохион байгуулалт мэргэжлийн удирдлагаар хангаж хяналт тавьж ажиллахыг Бодлого хэрэгжилтийн хэлтэс (С.Туул)-г даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2024 оны 05 дугаар сарын 31-ны
өдрийн А17 дугаар тушаалын хавсралт

“АВТОБУСТАЙ АЯЛАЛ” ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ЗАРДАЛ

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Автобусны түлш	Литр	115	3490 дт	400 000
2	Ус, ундаа	Ширхэг	45	5,000	225,000
3	Үзмэрийн үнэ	Ширхэг	45	10,000	450,000
				Нийт	1,075,000